

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-аар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн 7¹ дүгээр зүйлд заасны дагуу сум, дүүргийн төсвийн хөрөнгөөр хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Худалдан авах ажиллагааг Хуульд заасан аль ч журмаар зохион байгуулснаас үл хамааран захиалагч улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавих иргэдийг сонгон шалгаруулахад энэхүү журмыг мөрдөж болно.

1.3.Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад Сангийн сайдын баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичиг”-ийг хэрэглэнэ.

1.4.Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг Хууль, түүнд нийцүүлэн баталсан журам, зааврын дагуу зохицуулна.

1.5.Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерт оролцогч нь тухайн сум, дүүрэгт бүртгэлтэй, Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр байгуулагдсан иргэдийн бүлэг (цаашид “бүлэг” гэх) байна.

Хоёр. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулах

2.1.Энэ журмын дагуу зохион байгуулах төсөл, арга хэмжээ нь санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан, техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байна.

2.2.Бараа, ажил, үйлчилгээг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар сонгон шалгаруулахад захиалагч хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороо байгуулна.

2.3.Суманд сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүний нөөц хязгаарлагдмал бол захиалагч ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь сондгой тооны гишүүдтэй байна.

2.4. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцохыг хүссэн Иргэний хуулийн дагуу хамтран ажиллах гэрээ байгуулан бүлэг үүсгэсэн иргэд энэ журмын хавсралт дахь мэдүүлгийн маягыг бөглөн, иргэний үнэмлэх, бүлгийн танилцуулгын хамт сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдийн бүлэгт бүртгүүлэх тухай хүсэлт гаргана.

2.5. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцохыг сонирхсон бүлгээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн “Иргэдийн бүлгийн жагсаалт” (цаашид “жагсаалт” гэх)-ыг бэлтгэнэ. Бүлгээс ирүүлсэн бүх хүсэлтийг бүртгэж авна.

2.6. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар жагсаалтыг иргэд, олон нийтэд өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан ил тод, нээлттэй мэдээлнэ. Жагсаалтыг жил бүр шинэчлэн гаргана.

2.7. Бүлэг энэ журмын 2.5-д заасан жагсаалтад бүртгүүлснээр олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй болох бөгөөд Хуульд заасан журам, зааврыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

2.8. Бүлэг өөрийн саналаар жагсаалтаас гарах, шинээр жагсаалтад орох эрхийг энэхүү журмаар хязгаарлахгүй.

2.9. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулахад тендерийн урилгыг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.25, 52 дугаар зүйлийн 52.1.12-д заасан худалдан авах ажиллагааны цахим систем (цаашид “цахим систем” гэх) болон тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжих баг, хорооны Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт тус тус зарлаж, товлосон хугацаанд хүлээн авч, тендерийн нээлт хийж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ.

2.10. Захиалагч олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг урилгад хавсаргана.

2.11. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцохыг сонирхсон бүлэг энэ журмын 2.9, 2.10-д заасны дагуу тендерийн баримт бичигтэй цахим системээр дамжуулан танилцаж, үнэ төлбөргүйгээр татан авна.

2.12. Захиалагч тендерийн урилга тараасан хугацаанаас хойш тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй хоногоор тогтооно.

2.13. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцохыг сонирхсон бүлэг энэ журмын 2.10-д заасан тендерийн баримт бичгийн дагуу тендерийг бэлтгэж, энэхүү журмын 2.12-д заасан хугацааны дотор тендер илгээнэ.

2.14. Тендерт оролцогчоос ирүүлсэн тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэж, шаардлагад нийцсэн тендерийг хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, хуулийн 29 дүгээр зүйлд заасан гэрээ байгуулах эрх олгоно.

2.15. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тохиолдолд захиалагч тендерийн урилгыг дахин зарлана.

Гурав. Худалдан авах ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах

3.1.Бүлэг нь ахлагч, бусад гишүүдээс бүрдэнэ. Ахлагч нь тухайн сум, дүүрэгт бүртгэлтэй, байнгын оршин суугч иргэн байх бөгөөд бүлгийг төлөөлөх эрх, үүргийг хамтран ажиллах гэрээнд баталгаажуулсан байна.

3.2.Бүлгийн ахлагч нь бүлгийг төлөөлөн хариуцлага дангаар хүлээх бөгөөд хариуцлагыг бусад этгээдэд шилжүүлэх эрхгүй.

3.3.Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцохыг сонирхсон бүлэг тендер илгээхдээ энэ журмын 1.5-д заасан хамтран ажиллах гэрээг ирүүлэх бөгөөд уг гэрээ нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.3 дахь хэсэгт зааснаас гадна дараах шаардлагуудыг хангасан байвал зохино:

3.3.1.Бүлгийн ахлагч, гишүүдийг тус бүр томилсон байх,

3.3.2.Ахлагч захиалагчтай харилцах, бүлгийг төлөөлөн тендер илгээх, бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийх,

3.3.3.Нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн ахлагчтай тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх.

Дөрөв. Гэрээний гүйцэтгэлийн хяналт

4.1.Захиалагч болон хууль, хяналтын байгууллага, иргэд нь олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

4.2.Захиалагч олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавихдаа тухайн бараа, ажил, үйлчилгээний онцлогт нийцүүлэн дараах хоёр аргын аль нэгийг сонгон, хэрэгжүүлнэ:

4.2.1.Гэрээний хэрэгжилтэд тухайн сум, дүүрэгт бүртгэлтэй иргэдээс сонгон гүйцэтгэлийн хянагчаар томилж, дүгнэлт гаргуулах;

4.2.2.Тухайн орон нутгийн арваас доошгүй иргэдээс гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийн талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, үнэлэх.

4.3.Энэ журмын 4.2.1-д заасан гүйцэтгэлийн хянагч гэрээний хэрэгжилтийн хяналтыг өдөр тутам гүйцэтгэх бөгөөд захиалагч хууль, журамд нийцүүлэн урамшуулал олгож болно.

4.4.Захиалагч хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт заасны дагуу архивын нэгж үүсгэхдээ гэрээний хэрэгжилтэд хяналт тавьсан энэ журмын 4.2-д заасан гүйцэтгэлийн хянагчийн ажлын тайлан эсхүл сэтгэл ханамжийн судалгааг хавсаргана.

4.5.Захиалагч бүлгийн гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авахдаа анх тендер зарласан техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, техникийн тодорхойлолтод заасан тоо хэмжээнд үндэслэнэ.

Тав. Хариуцлага

5.1.Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа энэхүү журмын зүйл, заалтыг зөрчсөн этгээдэд хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2.Бүлэг худалдах, худалдан авах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй нь бүлгийн ахлагчийг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт заасан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах үндэслэл байна.

---oOo---

ИРГЭДИЙН БҮЛГИЙН ЖАГСААЛТАД ОРОХ МЭДҮҮЛЭГ

Дугаар

1. Иргэдийн бүлгийн мэдээлэл

1.1. Иргэдийн бүлгийн нэр:

1.2. Иргэдийн бүлгийн бүрэлдэхүүн:

| № | Эцэг/эх-ийн нэр | Өөрийн нэр | Регистрын дугаар | Оршин суугаа хаяг | Холбоо барих утасны дугаар, э.шуудангийн хаяг | Иргэдийн бүлгийн ахлагч, гишүүний аль нь болох | Иргэний үнэмлэхийн хуулбар хавсаргасан эсэх |
|----|-----------------|------------|------------------|-------------------|---|--|--|
| 1. | | | | | | | <input type="checkbox"/> тийм, <input type="checkbox"/> үгүй |
| 2. | | | | | | | <input type="checkbox"/> тийм, <input type="checkbox"/> үгүй |
| 3. | | | | | | | <input type="checkbox"/> тийм, <input type="checkbox"/> үгүй |
| 4. | | | | | | | <input type="checkbox"/> тийм, <input type="checkbox"/> үгүй |
| 5. | | | | | | | <input type="checkbox"/> тийм, <input type="checkbox"/> үгүй |

(гэх мэт)

1.3. Иргэдийн бүлгийн үйл ажиллагааны салбар, чиглэл:

1.3.1.

1.3.2.

1.3.3.

1.3.4.

1.3.5. (гэх мэт)

2. Мэдүүлгийн зорилго

2.1. Иргэдийн бүлгийн жагсаалтад шинээр бүртгүүлэх тийм, үгүй

2.2. Бүртгэлээ шинэчлүүлэх

тийм, үгүй

Хүсэлт гаргасан огноо:

Хүсэлт гаргасан:

Бүлгийн ахлагч: Нэр:

Гарын үсэг:

Бүлгийн гишүүд: Нэр:

Гарын үсэг:

Бүлгийн гишүүд: Нэр:

Гарын үсэг:

Бүлгийн гишүүд: Нэр:

Гарын үсэг:

Бүлгийн гишүүд: Нэр:

Хүсэлтийг бүртгэсэн:

Бүртгэсэн сум/дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан:

Нэр:

Гарын үсэг:

Бүртгэсэн огноо:

Иргэдийн бүлгийн жагсаалтыг байгууллагын цахим хуудаст нийтэлсэн огноо:

.....
Гарын үсэг:
.....